

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖИЙН БИЕЛЭЛТ**  
/2024 оны байдлаар/

Эрүүл мэндийн газар

2024 оны 12 дугаар сарын 04

№	Захирамжийн		Захирамжийн тэргүү	Захирамжийн агуулга	Хугацаа	Биелэлт	Үнэлгээ
	Дугаар	Огноо					
1	Б/06	2024.01.18	Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох тухай	Эрүүл мэндийн газрын төрийн албан хаагчдын нэрс, зэрэг дэвийг 12 дугаар хавсралтаар баталсугай. Хавсралтад нэр тусгагдсан төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв түүний нэмэгдлийг 2024 оны 01 сарын 01-ний өдрөөс мөрдөхийг холбогдох байгууллагуудад зөвшөөрсүгэй.	2024 оны 01 сарын 1-ээс	Эрүүл мэндийн газрын төрийн захиргааны 5 албан хаагчийн зэрэг дэвийг аймгийн Засаг даргын тус захирамжийн дагуу 2024 оны 01 сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудал, сургалт хариуцсан мэргэжилтэн С.Мөнхзулыг тэргүүн зэрэг, дэс түшмэл</li> <li>- Эмийн бодлогын хэрэгжилт чанар аюулгүй байдал эмийн зохистой хэрэглээ эм эмнэлгийн хэрэгслийн хангамж хариуцсан мэргэжилтэн О.Анхбаярыг дэд зэрэг, дэс түшмэл</li> <li>- Эрүүл мэндийн статистик мэдээллийн мэргэжилтэн Г.Итгэлийг дэд зэрэг, дэс түшмэл</li> <li>- Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Д.Лхагважавыг тэргүүн зэрэг, дэс түшмэл</li> <li>- Мэдээлэл технологи, цахим эрүүл мэнд, сүлжээ хариуцсан мэргэжилтэн Х.Оюун-Эрдэнийг дэд зэрэг, дэс түшмэл тус тус нэмэгдүүлсэн.</li> </ul>	100
2	А/26	2024.01.17	Цагаан тоосны бүсэд амьдарч байгаа иргэдэд эрүүл мэндийн үзлэг зохион байгуулах ажлын хэсэг томилж тухай	“Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах” арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Орхон аймгийн нөлөөллийн бүс (Баян-Өндөр сумын Говил баг, Вокзалын хэсэг, Жаргалант сум)-д байрлах иргэдэд эрүүл мэндийн үзлэг, шинжилгээг зохион байгуулах салбар хоорондын болон мэргэжлийн	2024.02.01	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 18/04 дугаар тогтоолын 6.4.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2024 оны “Цагаан тоосны бүсэд амьдарч байгаа иргэдэд эрүүл мэндийн үзлэг зохион байгуулах” А/26 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд ажлын хэсэг байгуулагдан тайлант хугацаанд 10 удаа хуралдан тухай бүр шийдвэрийг гарган хэрэгжүүлж ажилласан. Тайлант хугацаанд цагаан тоосны нөлөөллийн бүсийн 1866 иргэн болон нөлөөллийн бус бүсийн	100

				Ажлын хэсгийг нэгдүгээр, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ зохион байгуулах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.		193 иргэн нийт 2005 иргэнийг 7 төрлийн үзлэг шинжилгээнд бүрэн хамруулснаас Жаргалант сумын 696 иргэн, Баянцагаан багийн 170 иргэн, Говил багийн 946 иргэн, Гаалийн газрын 31 ажилтан, Төмөр замын 23 ажилтан, Цагдаагийн газрын 139 ажилтан тус тус хамрагдсан байна. Урьдчилсан сэргийлэх үзлэгээр хийгдсэн шинжилгээ үзлэгүүдийн дүгнэлтээр цагаан тоосны нөлөөллөөс үүссэн өвчлөл илрээгүй. Хүн амын дунд тархаад байгаа Халдварт бус өвчлөлийн шалтгаанууд нь нөлөөллийн бус бүсэд тамхины шалтгаантай, нөлөөллийн бүсэд халдварт бус болон коронавируст халдварын хавсарсан өвчлөлийн шалтгаантай байна. Тус үзлэг шинжилгээнд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас 741.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн.	
3	A/44	2024.01.18	Туслах сувилагч ажиллуулахад дэмжлэг үзүүлэх тухай	Бүсийн оношилгоо эмчилгээний төвд туслах сувилагч ажиллуулахад дэмжлэг үзүүлж, шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.	2024.01.18-ээс	Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, сувилагч нарын ажлын ачааллыг бууруулах зорилгоор Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 24 туслах сувилагч ажиллаж байна. Орон нутгаас 10 туслах сувилагчийн цалинд 50.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Туслах сувилагч нарыг хүлээн авах яаралтай тусламж, хүүхэд, хавдар, хөнгөвчлөхийн тасаг болон бусад ачаалал ихтэй тасагт томилон ажиллуулсан.	100
4	A/60	2024.01.25	Цалин хөлсний хэмжээ шинэчлэн тогтоох тухай	Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний төрийн байгууллагын хавсралтад нэр тусгагдсан удирдах ажилтнуудын цалин хөлсний хэмжээг шинэчлэн тогтоож 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.	2024 оны 01 сарын 01-ээс	Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/60 дугаар захирамжийн дагуу Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Сүхээгийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлд өөрчлөлт орж цалинг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлэн олгож эхэлсэн.	100
5	A/64	2024.01.25	Хөрөнгө гаргах тухай	Орхон аймгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн дунд мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, яаралтай	2024.01.25-ээс	Тус захирамжаар “Бид дорнын анагаах ухааны их эмч”, “Миний мэргэжил-Миний бахархал-Би эмч”, “Миний мэргэжил-Миний бахархал-Би сувилагч” сэдвүүдээр ажил мэргэжлийн уралдаан зохион	100

				тусламж үйлчилгээг үзүүлэх, чадавхыг нэмэгдүүлэх, багаар ажиллах чадвар хандлагыг төлөвшүүлэн дадлагажуулах, эрүүл мэндийн салбарууд хамтдаа хөгжих боломжийг сайжруулах зорилгоор “Миний мэргэжил-миний бахархал” ур чадварын уралдаан тэмцээн зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.		байгуулж нийт 104 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Үүний үр дүнд: - Уламжлалт анагаах ухааны эмч эмнэлгийн мэргэжилтний эмнэл зүйн мэдлэг дээшилсэн. - Эмч нарын яаралтай тусламж, үйлчилгээний оношилгоо, эмчилгээний дэвшилтэт технологи, ашиглах ур чадварыг дээшлүүлсэн. - Сувилахуйн тусламж үйлчилгээтэй холбоотой хууль эрх зүйн баримт бичиг тушаал шийдвэр, стандарт удирдамжийг уншиж судлан мэдлэгээ сэргээж, ур чадвараа нэмэгдүүлсэн. Дээрх ажил мэргэжлийн уралдаанд зориулан “Эмч” хөтөлбөрөөс 5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	
6	A/66	2024.01.26	Түргэн тусламжийн үйл ажиллагааны зардалд санхүүжилт олгох тухай	БОЭТ-ийн дэргэдэх “Түргэн тусламжийн төв”-ийн 2024 оны эхний хагас жилийн санхүүжилтэд шаардагдах төсвийн тооцоог хавсралтаар баталсугай.	2024 оны 01 сарын 01-ээс	Орон нутгийн төсвөөс БОЭТ-ийн Түргэн тусламжийн 4 эмч, 5 жолоочийн цалингийн асуудлыг шийдвэрлэсэн. Тайлант хугацаанд тус эмч, жолооч нар нь нийт 12242 түргэн тусламжийн дуудлагад очиж ажилласан. Нийт дуудлагын 16.1% осол гэмтлийн, 16.5%, алсын дуудлага 1,9% байна. Түргэн тусламжийн хүний нөөцийг нэмэгдүүлснээр 0-10 минутын хүлээгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 803 тохиолдлоор бууруулсан үр дүнтэй байна.	100
7	A/86	2024.02.09	“Эмч” хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны жилийн төлөвлөгөө төсвийг батлах тухай	“Эмч” хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны жилийн төлөвлөгөөг, төсвийг хавсралтаар баталсугай.	2024.02.09-өөс	Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын 2024 оны А/86-р захирамжаар “Эмч” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 130.0 сая төгрөг, аймгийн ИТХ-ын 2024 оны 18/05 тогтоолоор 20.0 сая төгрөг нэмэлтээр тус тус батлагдсан. Хөтөлбөрийн хүрээнд: - Бид дорнын анагаах ухааны их эмч”, “Миний мэргэжил-Миний бахархал-Би эмч”, “Миний мэргэжил-Миний бахархал-Би сувилагч” сэдвээр ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулж 104 эмч эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. - Эрүүл мэндийн байгууллагуудын 6 эмнэлгийн мэргэжилтэн БНСУ, 8 өрхийн эрүүл мэндийн төвийн дарга ӨМӨЗО-ны Хөх хотын эрүүл мэндийн байгууллагаас туршлага судалсан.	100

						<ul style="list-style-type: none"> <li>- 11 удаагийн сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөнд давхардсан тоогоор 1530 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.</li> <li>- Дэлхийн эмч нарын болон олон улсын сувилагчдын өдрийг тохиолдуулан зохион байгуулсан онол практикийн бага хуралд 106 судлаач оролцсон.</li> <li>- Эрдэнэт хотын “Илгээлтийн эзэд” эрүүл мэндийн салбарын 100 ахмадын уулзалтыг зохион байгуулсан.</li> <li>- Эрүүл мэндийн салбарын 36 ажилтанд 36,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</li> <li>- Эрүүл мэндийн байгууллагуудын 70 ажилтныг умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг, 24 ажилтныг бүдүүн гэдэсний дуранд хамруулсан.</li> </ul> <p>Тайлант хугацаанд төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь 14 байгаа нь өмнөх оноос 0,9%-аар нэмэгдсэн ба нийгмийн дэмжлэгт хамрагдсан хувь 27.8% байгаа нь өмнөх оныхоос 3.4 хувиар өссөн ба хөтөлбөрийн хэрэгжилт 98,7 хувьтай байна.</p>	
8	A/102	2024.02.14	Дэмжлэг үзүүлэх тухай	Орхон аймгийн Баян-Өндөр сумын Эрдэнэ багийн иргэн, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Халдвартын тасгийн ажилтан Т.Сайханчимэгийн гэр гал түймэрт өртөж, орон гэргүй болсон тул дэмжлэг үзүүлсүгэй.	2024.02.14	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Халдвартын тасгийн ажилтан Т.Сайханчимэгийн гэр гал түймэрт өртсөн тул 1.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	100
9	A/155	2024.03.04	Ажлын хэсэг байгуулах тухай	Хүн амын нас, хүйс эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг зохион байгуулан ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.	2024.03.04-өөс	Тус захирамжаар хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ оношилгоог нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах 17 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдан, Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны А/27 дугаар тушаалаар ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг	70

						<p>батлуулан үр дүнг тооцон ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувь байна. Тайлант хугацаанд улс орон даяар зохион байгуулагдаж байгаа урьдчилан сэргийлэх үзлэгт 63627 буюу нийт хүн амын 59,9 хувь байгаа бөгөөд улсын хэмжээнд 21 аймагтаа хамрагдалтаараа тэргүүлж байна. 0-17 насны 36641 хүүхэд буюу 97,9%, 18-с дээш насанд 26986 буюу 39,2 хувь үзлэгт бүрэн хамрагдсан. Үзлэгээр 55077 хүнд зөвлөгөө өгч, 5010 хүнийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хяналтад авч, 9337 хүнийг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт шилжүүлсэн байна. 87724 өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн ба хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэгээр амны хөндийн өвчлөл, насанд хүрэгчдийн үзлэгээр хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөл тэргүүлж байна. Тайлант хугацаанд ходоодны дурангийн шинжилгээнд 4822 хүн орсноос улаан хоолойн 19, ходоодны хавдар 41 илрүүлж, эрт үедээ оношлогдсон ходоод, улаан хоолойн 38 хавдрыг салст хуулах хагалгаагаар эмчлэн эрүүлжүүлсэн байна.</p>	
10	A/308	2024.03.18	Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх тухай	Захиргааны байгууллагуудын 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хэсгийг I, шаардагдах зардлыг II хавсралтаар тус тус баталсугай.	2024.03.18-2024.04.30	Байгууллагын 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хэсэгт хуваарийн дагуу үнэлгээ хийлгэсэн. 2023 оны байдлаар Эрүүл мэндийн газар хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр 71,66 буюу 4,48 оноотой үнэлэгдсэн. Үнэлгээний дүн, зөвлөмжийг албан хаагчдад танилцуулж, гүйцэтгэл сайжруулах төлөвлөлт гарган хэрэгжүүлсэн ба төлөвлөгөөний хэрэгжилт 93% байна.	100
11	A/229	2024.03.28	Хөрөнгө гаргах тухай	Аймгийн хэмжээнд донорын эгнээг өргөжүүлэх, цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэх, донор элсүүлэх ажлыг эрчимжүүлэх, донор хадгалах идэвх санаачилгыг өрнүүлэх чиглэлээр "Тогтмол хугацаанд цус, сийвэнгээ	2024.03.28-аас	Аймгийн Засаг даргын 2024 оны A/229 дугаар захирамжаар 8,0 сая төгрөгийг шийдвэрлэж, "Тогтмол хугацаанд цус, сийвэнгээ бэлэглэе" уриан дор сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлэх, цусны аюулгүй байдлыг хангах, донор хадгалах идэвх санаачилгыг өрнүүлэх аяныг зохион байгуулсан.	100

				бэлэглэе” уриан дор зохион байгуулах аяны удирдамжийг нэгдүгээр, төсвийн тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.		Суурин цус цуглуулалтаар 562 донороос 562 нэгж цус, шинэ 140 донороос 140 нэгж цус цуглуулсан. Цусны салбар төвд бүртгэлтэй 562 донорт цусны АВО, Резус бүлэг, Келл бүлэг, цус, цусан бүтээгдэхүүнээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээг хийж 100% баталгаажуулсан ба резус эерэг 560, сөрөг 2 донор бүртгэгдсэн. Цус цусан бүтээгдэхүүн сэлбэх тусламж үйлчилгээний бэлэн байдлыг үнэлэх чиглэлээр 67 эмч эмнэлгийн мэргэжилтнийг сургалтад хамруулсан. Тайлант хугацаанд 1152 нэгж цус цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэснээс 908 нэгж цус цусан бүтээгдэхүүнийг зарцуулсан байна. Цус цусан бүтээгдэхүүн сэлбэлттэй холбоотой урвал хүндрэл 2 бүртгэгдсэн. Тайлант хугацаанд цус цусан бүтээгдэхүүний хангалт 100%-тай байна.	
12	A/233	2024.03.29	Хөрөнгө гаргах тухай	Сүрьеэгийн эрсдэлт бүлэг, хавьтлын идэвхтэй илрүүлэг үзлэг шинжилгээ зохион байгуулах нэгдсэн удирдамжийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.	2024.03.28-өөс	Эрүүл мэндийн газрын даргын “Идэвхтэй илрүүлэг үзлэг шинжилгээ зохион байгуулах, хөрөнгө гаргах тухай” А/23 дугаар тушаалын дагуу 4 сарын 01-23-ний өдрүүдэд дараах үе шаттайгаар зохион байгуулж ажилласан. Илрүүлэг үзлэгийг зохион байгуулж буй цэгүүдэд дэмжлэгт хяналтын 2 баг өдөр бүр үзлэг эхлэхийн өмнөх, явцын, төгсгөлийн хяналтыг хийж, үнэлгээний хуудас хөтөлж, арга хэмжээг тухай бүр авч ажилласан. Илрүүлэг шинжилгээнд нийт 575 хүн хамрагдахаас 543 /94,3%/ хамрагдаж, сүрьеэтэй байж болзошгүй 179/33%/ тохиолдлоос холбогдох шинжилгээ авч, 26 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнээс сорилд 115, цэрний шинжилгээнд 64 хүнийг хамруулснаас цэрний шинжилгээгээр батлагдсан тохиолдол байхгүй, сорил эерэг 26 илрүүлж, эмчилгээнд хамруулсан байна.	100
13	Б/09	2024.04.01	Д.Сүхээг албан үүрэг түр орлон гүйцэтгэгчээс чөлөөлөх тухай	Цогтбаатарын Мөнхцэцэгийг аймгийн Эрүүл мэндийн газрын даргын албан тушаалд эгүүлэн томилох болсонтой холбогдуулан Даваанямын Сүхээг 2024 оны 04 дүгээр	2024.04.01	Цогтбаатарын Мөнхцэцэгийг аймгийн Эрүүл мэндийн газрын даргын албан тушаалд эгүүлэн томилох болсонтой холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг тор орлон гүйцэтгэгч албан тушаалаас Даваанямын Сүхээг	100

				сарын 01-ний өдрөөс Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.		2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс чөлөөлсөн.	
14	Б/10	2024.04.01	Ц.Мөнхцэцэгийг албан тушаалд эгүүлэн томилох тухай	Цогтбаатарын Мөнхцэцэгийг 2024 оны 04 сарын 01-ний өдрөөс аймгийн Эрүүл мэндийн газрын даргын албан тушаалд эгүүлэн томилсугай.	2024.04.01-ээс	Цогтбаатарын Мөнхцэцэгийг 2024 оны 04 сарын 03-ны өдрөөс аймгийн Эрүүл мэндийн газрын даргын албан тушаалд эгүүлэн томилсон. Ажил хүлээлцэх комиссын даргаар аймгийн ЗДТГ-ын Хууль эрхзүйн хэлтсийн дарга, нарийн бичгийн даргаар ЭМГ-ын Хүний нөөцийн төлөвлөлт хангалт мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн, гишүүнээр аймгийн ЗДТГ-ын хууль эрхзүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Баттүвшин, аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн О.Батцэнгэл нар томилогдсон бөгөөд ЭМГ-ын Хүний нөөцийн төлөвлөлт хангалт мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн ажил хүлээлцэх актыг үйлдэж Орхон аймгийн Төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн даргад хүлээлгэн өгсөн.	100
15	A/252	2024.04.09	Үнэлгээний баг байгуулах тухай	Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулсан гүйцэтгэлийн гэрээг дүгнэх “Үнэлгээний багийн бүрэлдэхүүн”-ийг нэгдүгээр, “Үнэлгээний багийн ажиллах журам”-ыг хоёрдугаар, “Өрхийн эрүүл мэндийн төвийн гэрээний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт”-ийг гуравдугаар, “Гэрээний биелэлтийн үнэлгээний дүнгийн нэгтгэлийн загвар”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.	2024.04.09-өөс	Эрүүл мэндийн сайдын 2024 оны “Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журмыг батлах тухай” А/122 тоот тушаалын дагуу өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулсан гэрээний гүйцэтгэлийг үнэлэх үнэлгээний баг, журам, шалгуур үзүүлэлтийг шинэчлэн баталсан. Батлагдсан захирамжийг салбарын шуурхай болон өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, ахлагч нарт 2 удаа танилцуулж, мэдээлэл хийсэн. Гэрээний гүйцэтгэлийн хэрэгжилтийг жилд 2 удаа тухайн жилийн 7-р сарын дотор, дараа жилийн 1-р сарын дотор үнэлэхээр тусгагдсан бөгөөд тайлант хугацаанд эхний хагас жилийн хэрэгжилтийн үнэлгээ хийсэн. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн	100

						гүйцэтгэлийн гэрээний дундаж 92,7% болж, өмнөх оны мөн үеэс 5,4%-аар нэмэгдсэн байна.	
16	A/298	2024.04.23	Хөрөнгө гаргах тухай	“Нүүдлийн эмнэлгийг ажиллуулан урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ оношилгоог эрчимжүүлэх” үйл ажиллагааны удирдамжийг нэгдүгээрт, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.	2024.04.23-аас	Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/150 тоот тушаалаар “Нүүдлийн эмнэлгийг орон нутагт ажиллуулан урьдчилан сэргийлэх, үзлэг, шинжилгээ, оношилгоог идэвхжүүлэх” ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2024 оны А/298 захирамжаар 2.6 сая төгрөгийн дэмжлэгийг орон нутгийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэн Улсын хоёрдугаар төв эмнэлгийн эмч эмнэлгийн мэргэжилтний баг 15 багийн 618 иргэнийг насны багцын дагуу урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Үүнээс эрэгтэй 235, эмэгтэй 323 хамрагдсан. 4 насны багцаар нүүдлийн эмнэлгийн хүчин чадлын хэмжээгээр ходоодны дуранд 171 иргэн, дүрс оношилгоо 539 иргэн, зүрх судасны эмчийн үзлэг 561, чих хамар хоолой эмчийн үзлэг, цээжний рентген, лабораторийн лавлагаа шинжилгээнүүдэд 618 иргэн тус, тус хамруулснаар урьдчилан сэргийлэх үзлэг 0,6 хувиар нэмэгдсэн. Үзлэгээр дийлэнх хувь нь хоол боловсруулах эрхтэн тогтолцоо, зүрх судасны эрхтэн тогтолцооны өвчлөл байна.	100
17	A/330	2024.05.03	Эрүүл мэндийн салбарын ажилтнуудад дэмжлэг олгох тухай	Эрүүл мэндийн салбарын эмч ажилтнуудад дэмжлэг үзүүлэх зөвлөлийн 2024 оны 04 сарын 26-ны өдрийн анхдугаар хурлын шийдвэрээр нийгмийн дэмжлэгт хамрагдах эрүүл мэндийн салбарын 36 ажилтнуудын нэрс, тэтгэмжийн хэмжээг хавсралтаар баталсугай.	2024.05.03-аас	Тус захирамжаар байгуулагдсан Эрүүл мэндийн салбарын ажилтнуудад дэмжлэг үзүүлэх зөвлөлийн 2024 оны анхдугаар хуралдааны шийдвэрийн дагуу эрүүл мэндийн салбарын нийт 36 эмч ажилтанд 38.7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлснээс сургалтын ном, хэвлэлийн чиглэлээр 4, гадаад сургалтын чиглэлээр 7, эмчилгээ, оношилгооны чиглэлээр 2, дотоод сургалтын чиглэлээр 23 ажилтанд тус тус дэмжлэг үзүүлсэн байна.	100
18	A/322	2024.05.03	Хурдан морины уралдаан зохион байгуулах тухай	2.Хурдан морины уралдааныг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг “Эрдэнэт хүлэг” Морин спорт уяачдын холбоо (Т.Батмөнх), Баян-Өндөр сум (Б.Баасансүрэн),	2024 оны 05 дугаар сарын 04-ний өдрөөс 08-ний өдрүүдэд	Хурдан морины уралдааныг зохион байгуулах үеэр Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн түргэн тусламжийн эмч, жолоочийг томилон ажиллуулж яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангаж ажилласан. Уралдааны үеэр осол гэмтэл бүртгэгдээгүй.	100



				Жаргалант сум (Б.Зоригтбаяр), хурдан морины уралдаанч хүүхдийн бүртгэл хийж, аюулгүй байдлыг хангаж, хяналт тавьж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар (А.Наранболд), Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (Х.Эрдэнэбат), Эрүүл мэндийн газар (Ц.Мөнхцэцэг), Цагдаагийн газар (А.Лхагвадорж)-т тус тус үүрэг болгосугай.			
19	A/349	2024.05.10	Ажлын хэсэг байгуулсугай.	Аймгийн хэмжээнд Олон улсын хүүхдийн эрхийн өдрийг угтан Хүүхдийн хөгжил, хамгаалал уриан дор олон талт үйл ажиллагааг зохион байгуулсугай.	2024.05.10-2024.06.01	Олон улсын хүүхдийн эрхийн өдрийг угтан хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр олон талт үйл ажиллагаа зохион байгуулах Засаг Даргын А/349 дугаар захирамжаар батлагдсан ажлын хэсэг салбар нэгжүүдээс зохион байгуулах үйл ажиллагаа, тэдгээрийн бэлтгэл ажлыг хангах талаар хэлэлцэж 4 удаа хуралдсан. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг “Эрдэнэт-Хүүхэд Хөгжил” уриан дор зохион байгуулж, Эрүүл мэндийн газраас хүүхдийн хөгжлийг дэмжих, шүдний эрүүл ахуйн ач холбогдлыг таниулан сурталчлах, гараа зөв угаах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эцэг эхчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох гэсэн 4 чиглэлээр оролцож, нийт 200 хүүхдэд гар угаах, шүд угаах заавар бүхий 2 төрлийн 400 ширхэг гарын авлагыг түгээж, эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээллийг өглөө. Түүнчлэн Орхон аймгийн Шүдний мэргэжилтнүүдийн холбоотой хамтран шүдээ зөв угаах гарын авлага бүхий зааварчилгааг өгч, хүүхдийн шүдний зориулалтын сойзыг 150 хүүхдэд бэлэглэсэн. Нийтийг хамарсан баяр ёслолын үеийн яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангаж Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн түргэн тусламжийн эмч болон машиныг талбайд	100

						бэлтгэж эмнэлгийн тусламжийн бэлэн байдлыг хангаж ажилласан. Эрүүл ахуйн улсын байцаагч, хүүхдийн байцаагчтай хамтран худаалагдаж буй хоол хүнсэнд эрүүл ахуйн хяналт хийж, нийтийг хамарсан хордлого, гэдэсний халдвараас урьдчилан сэргийлж хүүхдийн аюулгүй байдлыг хангаж ажилласан.	
20	A/379	2024.05.22	Дэмжлэг үзүүлэх тухай	Аймгийн өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбооны гишүүд Сингапур улсад зохион байгуулагдах Дэлхийн өрхийн эмч нарын Ази номхон далайн бүсийн 26 дугаар их хуралд оролцож, Сингапур, Малайз улсын өрхийн эмнэлгийн үйл ажиллагаатай танилцаж мэргэжлийн туршлага солилцоход санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.	2024.05.22-оос	Орхон аймагт 8 өрхийн эрүүл мэндийн төв дарга нар Сингапур улсад зохион байгуулагдсан Дэлхийн өрхийн эмч нарын Ази номхон далайн бүсийн 26 дугаар их хуралд оролцож, Сингапур, Малайз улсын өрхийн эмнэлгийн үйл ажиллагаатай танилцаж мэргэжлийн туршлага солилцсон бөгөөд тус захирамжаар нийт 8.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.	100
21	A/472	2024.06.24	Хөрөнгө гаргах тухай	1. Нийгмийн халамж нэн шаардлагатай бүлгийн жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн аминдэмжүүлэх, дархлааг дэмжих арга хэмжээний удирдамжийг нэгдүгээр, зардалд шаардагдах санхүүжилтийг хоёрдугаар хавсралтаар батлан дэмжлэг үзүүлсүгэй	2024.06.24-өөс	Нийгмийн халамж нэн шаардлагатай бүлгийн жирэмсэн болон хөхүүл эхийг аминдэмээр хангах зорилгоор аймгийн Засаг даргын 2024 оны А/472 дугаар захирамжаар батлагдсан 10.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн эмчилгээний зорилгоор 243, урьдчилан сэргийлэх тунгаар 644, нийт 887 жирэмсэн болон хөхүүл эхийг аминдэмжүүлсэн. Аминдэмжүүлэлтэд хамрагдсан нийт 887 эхээс 243 буюу 27,4 хувь нь цус багадалттай эх байгаа ба эх барихын хүндрэлгүй төрүүлсэн. Тайлант хугацаанд аминдэмд хамрагдах эхийн тоо өмнөх онтой харьцуулахад 1.2 дахин нэмэгдсэн.	100
22	A/493	2024.07.02	Хариуцлагатай эргүүл, жижүүрийг ажиллуулах тухай	Үндэсний их баяр наадам, бүх нийтийн амралтын өдрүүдэд аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, аж ахуйн нэгж, байгууллагуудын хэвийн үйл	2024.07.02-2024.07.16	Засаг даргын 2024 оны А/493 дугаар захирамжийг үндэслэн ЭМГ-ын даргын 2024 оны А/58 дугаар тушаалаар 2024 оны 7 сарын 10-аас 7 сарын 16-ны өдрүүдэд Орхон аймгийн баяр наадмын үеийн хүнсний үйлдвэрлэл, худалдаа, хоол үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавих, нийгмийн эрүүл мэндийн ноцтой	100

				ажиллагааг хангах, хяналт тавих зорилгоор 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс 2024 оны 07 дугаар сарын 16-ны өдөр хүртэл хугацаанд ажиллах хариуцлагатай эргүүл, жижүүрийн хуваарийг хавсралтаар баталж, томилсугай		байдлын үед дуудагдан ажиллах албан хаагчийн хуваарь, баяр наадмын үеийн тусламж үйлчилгээ болон Эрүүл мэндийн байгууллагуудын ажиллах хуваарийг батлан, баяр наадмын өдрүүдээр хариуцлагатай жижүүрийг томилон үүрэгжүүлж, эм эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг ханган, эмнэлгийн тусламж үйлчилгээг тасралтгүй шуурхай үзүүлэхийг бүх шатны захирал, дарга нарт үүрэг болгон уг тушаалыг байгууллагуудад хүргүүлж, хариуцлагатай жижүүрүүд хяналт тавьж, эргэн мэдээллээр ханган ажилласан. Салбарын хяналтын газрын даргын баталсан удирдамжийн дагуу цэнгэлдэх хүрээлэн, морь барианы газарт 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрөөс 2024 оны 7 дугаар сарын 16-ны өдрүүдэд Эрүүл мэндийн газраас 3, Хүнс хөдөө аж ахуйн газраас 3 байцаагч хяналт тавьж, зөвлөмж өгч ажилласан.	
23	A/586	2024.08.22	Улаанбурхан өвчний эсрэг хариу арга хэмжээг зохион байгуулах, хөрөнгө гаргах тухай	Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг нэмэлт дархлаажуулалт болон бэлэн байдлыг хангахад шаардагдах төсвийг нэгдүгээр, улаанбурхан өвчнөөс сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, үйл ажиллагааны төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.	2024.08.22-оос	Эрүүл мэндийн газрын даргын “Улаанбурхан өвчний эсрэг хариу арга хэмжээг эрчимжүүлэх тухай” А/71 дугаар тушаалын дагуу арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд: - Эрүүл мэндийн байгууллагуудын улаанбурхан өвчний эсрэг хариу арга хэмжээний бэлэн байдалд 2 удаагийн дэмжлэгт хяналт хийж, зөвлөмжөөр хангасан. - Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, болзошгүй цар тахлын үеийн тохиолдол удирдлагын тогтолцоо чадавхжуулах, салбар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагаа сайжруулах 2 удаагийн сургалт хийж, 100 хүн хамрагдсан. - Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн дархлаажуулалт төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, 806 эрүүл мэндийн байгууллагын ажилтнаас 700 буюу 86,4%, Улаанбурхан, гахайн хавдар, улаанууд өвчний эсрэг товлолын вакцины нөхөн дархлаажуулалтад	100

						<p>1-р тун 108, 2-р тунд 294 хүүхэд нөхөн хамрагдсан.</p> <p>- Улаанбурхан, улаануудын нэмэлт дархлаажуулалтад 2024 онд тус дархлаажуулалтаас хоцорсон 1636 хүүхдийг хамруулсан.</p> <p>- Дархлаажуулалтад бүрэн хамрагдсан 2006-2018 онд төрсөн 13652 хүүхдийн мэдээллийг цахимд нөхөн оруулсан байна.</p>	
24	A/593	2024.08.27	Дэмжлэг үзүүлэх тухай	“Олон улсын сувилагчдын эрхийг хамгаалах өдөр”-ийг угтан нийгмийн дэмжлэгт хамруулах 4 сувилагчийн нэрс, тэтгэмжийн хэмжээг хавсралтаар баталсугай.	2024.08.27	“Олон улсын сувилагчдын эрхийг хамгаалах өдөр”-ийг угтан аймгийн ЗДТГ-аас нийгмийн дэмжлэгт эрүүл мэндийн салбартаа ажил үйлсээрээ манлайлан, үр бүтээлтэй ажиллаж байгаа сувилагч нарыг БНХАУ, Япон-Монгол, Улсын гуравдугаар төв эмнэлгийн үйл ажиллагаатай танилцан, туршлага судлуулж, богино хугацааны сургалтад хамруулсан. Тус сургалтад “Анхны оч” өрхийн эрүүл мэндийн төв, “Очир-Увидас”, “Нейрон” хувийн хэвшлийн клиник, Эрдэнэт сувиллын цогцолборын 4 сувилагч оролцож, эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудлыг дэмжих “Эмч” хөтөлбөрөөс 3.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	100
25	A/595	2024.09.02	Хөрөнгө гаргах тухай	Өмнөговь аймагт зохион байгуулагдах “Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх нь” зөвлөлдөх уулзалт, Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд ЭМЯ, 21 аймгийн ЭМГ-уудын дундах спортын IV бага наадамд оролцох 25 эмч нарын төсвийг хавсралтаар баталсугай.	2024.09.07.08 өдрүүдэд	Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудын удирдах ажилтны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүйн мэдлэг, ур чадварыг сайжруулах, ажлын гүйцэтгэлийн үнэлгээг бодитой хийж, хэрэгжүүлэх, удирдлагын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын удирдах ажилтныг чадавхжуулах сургалтад Орхон аймгийн эрүүл мэндийн газраас 25 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон. Спортын VI-р бага наадамд 24 багийн 470 гаруй тамирчид 3 төрлөөр / Волейбол, сагсан бөмбөг 3x3, теннис/ авхаалж самбааг уралдуулан өрсөлдөж, Орхон аймаг эмэгтэй сагс 3x3 төрөлд мөнгөн медаль авч амжилттай оролцсон.	100

26	A/725	2024.10.15	Дэмжлэг үзүүлэх тухай	БНСУ-ын Бусан хотод болох “Олон улсын эрүүл мэндийн аялал жуулчлалын 2024 оны конвенц”-д оролцох Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэнд хариуцсан О.Батцэнгэл, БОЭТ-ийн дэд захирал М.Алтанбек нарт тус бүр 4.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.	2024.10.15	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн асуудал хариуцсан О.Батцэнгэл, БОЭТ-ийн дэд захирал М.Алтанбек нар нь БНСУ-ын Бусан хотод болсон “Олон улсын эрүүл мэндийн аялал жуулчлалын 2024 оны конвенц”-д оролцон мэдээллээр хангасан.	100
27	A/772	2024.10.29	Эрүүл мэндийн салбарын ажилтнуудад дэмжлэг үзүүлэх	Эрүүл мэндийн салбарын эмч, ажилтнуудад дэмжлэг үзүүлэх зөвлөлийн 2024 оны 10 сарын 23-ны өдрийн 2-р хурлын шийдвэрээр нийгмийн дэмжлэгт хамрагдах эрүүл мэндийн салбарын ажилтнуудын нэрс тэтгэмжийн хэмжээ, шаардлагтай зардлыг хавсралтаар баталсугай.	2024.10.29	Аймгийн Эрүүл мэндийн салбарын ажилтнуудад дэмжлэг үзүүлэх зөвлөлийн 2024 оны 2-р хуралдааны шийдвэрийн дагуу Эрүүл мэндийн салбарын 5 ажилтанд нийт 8.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Үүнд. - Эрүүл мэндийн чиглэлээр 2 албан хаагчид нийт 4.0 сая төгрөг - Гадаад сургалтын чиглэлээр 3 эмчид нийт 4.0 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсэн байна.	100
28	A/821	2024.11.21	Ажлын хэсэг шинэчлэн байгуулах, хөрөнгө арга тухай	2. Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг зохион байгуулан мэргэжлийн арга зүйгээр ханган ажиллахыг Эрүүл мэндийн газар (Ц.Мөнхцэцэг), хүүхдийн байгууллагад халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлж ажиллахыг Боловсролын газар (О.Ариунгэрэлт) нарт тус тус үүрэг болгосугай.	2024.11.21-ээс	Тус захирамжаар томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг зохион байгуулах салбар дундын ажлын хэсгийг 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж 1 удаа хуралдан Томуугийн үндэсний нэгжийн дэмжлэгт хяналтын дүгнэлт зөвлөмжийг хэлэлцэн, вируслогийн сорьц авч үүсгэгч тодорхойлох, өвчлөлийг зөв бүртгэх, сургалт сурталчилгааг тогтмолжуулах, амны хаалт, спиртэд суурилсан гар халдваргүйжүүлэгч бодисыг тогтмол хэрэглэх чиглэлээр аж ахуйн нэгж, иргэдэд уриалах зэрэг шийдвэрийг гаргаж хэрэгжүүлж ажилласан. Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед өрхийн эрүүл мэндийн төвүүдийг илүү цагаар ажиллуулах нэмэгдэл хөлсийг тооцож олгох, гэрийн эргэлтийн шатахууны зардалд орон нутгаас 20.0 сая төгрөгийг шийдвэрлэсэн. Жаргалант сумын болон өрхийн эрүүл мэндийн төвүүд нь ЭМГ-ын	100

					<p>даргын 2024 оны А/90 дугаар тушаалын дагуу томуу томуу төст өвчний алаг цоог дэгдэлтийн үед гэрийн эргэлтэд бүрэн шилжиж, 5 хүртэл насны хүүхдийн идэвхтэй хяналт, дархлаажуулалт, зорилтот бүлгийн жирэмсэн, ахмад, хэвтрийн үйлчлүүлэгчид гэрээр эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гэрийн эргэлт өмнөх оны мөн үеэс (+0.5%) –аар нэмэгдсэн байна. 2024 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс Бүсийн оношилго эмчилгээний төвийн Хүүхдийн тасгийн хүлээн авахад 39 өрхийн эмчийг амралтын өдрүүдэд 14:00-22:00 цаг хүртэл дайчлан ажиллуулах хуваарь батлан, хуваарийн дагуу ажиллаж илүү цагаар ажиллуулж байна. Мөн өрхийн эрүүл мэндийн төвүүд нь томуу томуу төст өвчний үед өдрийн эмчилгээг эрүүл мэндийн даатгалаар үнэ төлбөргүй үзүүлж нийт 364 хүүхдийг өдрийн эмчилгээнд хамруулж эм, аминдэмийн багц олгосон. Захирамжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 2 удаагийн сургалтад 84 эмч, мэргэжилтнийг хамруулж, анхан болон лавлагаа шатлалын тусламж үйлчилгээнд 1 удаа дэмжлэгт хяналт хийж зөвлөмжөөр хангасан.</p>	
<b>Хэрэгжилтийн дундаж хувь-98,9%</b>						

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Г.ЭНХЖАРГАЛ

ТАНИЛЦСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА

Ц.МӨНХЦЭЦЭГ